

PHILIPS

BHS510
BHS515



Хэрэглэгчийн гарын авлага

Худалдан авалт хийсэнд тань баярлалаа, Philips-д тавтай морилно уу! Philips-ийн санал болгож буй тусламж үйлчилгээний ашиг тусыг бүрэн хүртэхийн тулд бүтээгдэхүүнээ www.philips.com/welcome хаягаар бүртгүүлнэ үү.

1 Чухал

Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг ашиглахын өмнө энэхүү хэрэглэгчийн гарын авлагыг сайтар уншиж, дараа ашиглах үүднээс хадгална уу.

- АНХААРУУЛГА: Энэхүү гэр ахуйн цахилгаан хэрэгслийг усны ойролцоо ашиглаж болохгүй.
- Усны ойролцоо ашиглах нь цахилгаан хэрэгсэл унтраалттай үед ч эрсдэлтэй тул гэр ахуйн цахилгаан хэрэгслийг угаалгын өрөөнд ашиглах үедээ ашиглаж дууссаны дараа залгуураас салгана уу.
- АНХААРУУЛГА: Энэхүү гэр ахуйн цахилгаан хэрэгслийг банн, шүршүүр,



угаалтуур эсвэл ус агуулсан бусад савны ойролцоо ашиглаж болохгүй.

- Ашигласны дараа тус гэр ахуйн цахилгаан хэрэгслийг үргэлж салгана.
- Хэрэв гол тэжээлийн утас гэмтсэн бол та үүнийг Philips, Philips-ийн эрх бүхий үйлчилгээний төв эсвэл түүнтэй ижил хэмжээнд мэргэшсэн хүнээр болзошгүй аюулаас зайлсхийх зорилгоор солиулах шаардлагатай.
- Энэ гэр ахуйн хэрэгслийг 8 болон түүнээс дээш насны хүүхдүүд, мөн учирч болох аюулыг нь ойлгуулж, тус гэр ахуйн цахилгаан хэрэгслийг ашиглахтай холбогдуулан заавар өгч, хараа хяналттай байлгаж байгаа бол бие мах бодын, мэдрэхүйн болон оюуны чадамж багатай, туршлагагүй хүмүүс ашиглаж болно. Хүүхдүүдийг тус гэр ахуйн цахилгаан хэрэгслээр тоглуулж болохгүй. Цэвэрлэх болон хэрэглэгчийн засварын үйл ажиллагааг хүүхдүүд хараа хяналтгүй хийж болохгүй.

- Нэмэлт хамгаалалтын үүднээс, бид танд угаалгын өрөөг цахилгаанаар хангадаг цахилгаан хэлхээнд хамгаалалтын унтраах төхөөрөмж (RCD) суурилуулахыг зөвлөж байна. Энэхүү RCD нь 30mA-аас ихгүй нэрлэсэн үлдэгдэл ажиллаж буй гүйдэлтэй байх шаардлагатай. Суурилуулж буй хүнээс зөвлөгөө авна уу.
- Та гэр ахуйн цахилгаан хэрэгслийг холбохын өмнө тус цахилгаан хэрэгсэл дээр заасан хүчдэл орон нутгийн тэжээлийн хүчдэлд тохирч буй эсэхийг шалгаарай.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг хэрэглэгчийн гарын авлагад зааснаас өөр ямар нэг зорилгоор ашиглах ёсгүй.
- Энэхүү гэр ахуйн цахилгаан хэрэгслийг хиймэл үсэн дээр ашиглаж болохгүй.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг тэжээлд холбосон үед харгалзах хүнгүйгээр орхиж болохгүй.
- Philips тусгайлан зөвлөөгүй л бол аливаа туслах хэрэгсэл болон бусад үйлдвэрлэгчдийн эд ангиыг ашиглаж огт болохгүй. Хэрэв та ийм дагалдах хэрэгсэл, эд анги ашигладаг бол таны баталгаа хүчингүй болно.
- Гол тэжээлийн утсыг гэр ахуйн цахилгаан хэрэгслийг тойруулан ороож болохгүй.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг хадгалахын өмнө хөрөх хүртэл нь хүлээнэ үү.
- Маш их халсан байж болзошгүй тул гэр ахуйн цахилгаан хэрэгслийг ашиглахдаа бүрэн анхааралтай байгаарай. Бусад хэсэг нь халсан байх тул зөвхөн бариулаас барьж, арьсанд хүрэлцэхээс зайлсхий.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг халуунд тэсвэртэй, тогтвортой тэгш гадаргуу дээр үргэлж байрлуулна уу. Үсний индүүг гадаргуу эсвэл бусад шатамхай материалд хэзээ ч хүргэж болохгүй.
- Гол тэжээлийн утсыг гэр ахуйн цахилгаан хэрэгслийн халсан хэсгүүдэд хүрэлцэхээс зайлсхий.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг асаалттай байгаа үед шатамхай эд зүйлс болон материалаас хол байлгана уу.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг халсан байгаа үед ямар нэг зүйлээр (жишээ нь, алчуур эсвэл даавуу) хэзээ ч бүтээж болохгүй.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг зөвхөн хуурай үсэн дээр ашиглана.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг чийгтэй гараар ажиллуулж болохгүй.

- Үсний индүүг цэвэр байлгаж, үсний хөөс, цацлага болон гель зэрэг үс хэлбэржүүлэх бүтээгдэхүүнүүд болон шорооноос хол байлга. Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг үс хэлбэржүүлэх бүтээгдэхүүнүүдтэй хэзээ ч хамт хэрэглэж болохгүй.
- Үсний индүү нь бүрээстэй байдаг. Энэхүү өнгөлгөө цаг хугацааны явцад аажмаар элэгдэж болно. Гэсэн хэдий ч энэ нь тус гэр ахуйн цахилгаан хэрэгслийн гүйцэтгэлд нөлөөлөхгүй.
- Хэрэв тус гэр ахуйн цахилгаан хэрэгслийг будагтай үсэнд хэрэглэсэн бол үсний индүүнд толбо тогтож болзошгүй.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг шалгаж эсвэл засварлахын тулд ямагт Philips-ийн эрх бүхий үйлчилгээний төвд буцааж өгнө үү. Мэргэжлийн бус хүнээр засварлуулах нь хэрэглэгчид маш аюултай нөхцөл байдал үүсгэж болзошгүй.
- Цахилгаанд кохиулаас сэргийлж агаар нэвтрүүлэгчид металл эд зүйл оруулж болохгүй.
- Ашигласны дараа тэжээлийн утсыг татаж болохгүй. Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг салгахдаа үргэлж залгуурыг барина уу.
- Түлэгдэх аюултай. Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг нэн ялангуяа ашиглаж буй болон хөргөж буй үед бага насны хүүхдээс хол байлга.

Цахилгаан соронзон орон (EMF)


Энэ Philips-ийн цахилгаан хэрэгсэл нь цахилгаан соронзон оронд өртөх магадлалтай холбогдуулан зохих бүх стандарт, дүрэм журмыг мөрддөг.

Дахин боловсруулах

- Энэ тэмдэг нь тус бүтээгдэхүүнийг энгийн гэр ахуйн хог хаягдалтай (2012/19/EU) хамт хаяж болохгүй гэсэн утгатай.
- Цахилгаан болон электрон бүтээгдэхүүнийг тусад нь цуглуулах талаарх өөрийн улсын дүрэм журмыг мөрдөнө үү. Хог хаягдлыг зохистой хаях нь байгаль орчин болон хүний эрүүл мэндэд сөрөг үр дагавар учруулахаас сэргийлэхэд тустай.



2 Ерөнхий мэдээлэл



① Дэлгэцийн самбар

③ Асаах/унтраах товч

⑤ Өлгөдөг гогцоо

⑦ Халдаг дэвсгэр

② Халаах хавтан

④ Температур тохируулагч



⑥ Хаах түгжээ

3 Хэрэглэхийн өмнө

- Шулуун боллогчийг зөвхөн үсээ хуурай үед ашиглана.
- Үснийхээ төрлийн дагуу хүссэн тохиргоогоо сонго. Дараах хүснэгтээс харна уу. Индүүг анх удаа ашиглахдаа үргэлж бага тохиргоог сонгоорой.

Үсний Төрөл	Температурын хүрээ
Өтгөн, ширүүн, буржгар, шулуун болгоход хэцүү	210-230°C
Хэвийн, дунд зэргийн бүтэцтэй эсвэл зөөлөн долгионтой	180-200°C
Шингэн, цайвар, шаргал, цайруулсан эсвэл будагтай	170°C буюу түүнээс доош

4 Үсээ шулуун болгох





1 Асаах/унтраах товчийг ③ (③) дэлгэцийн самбарын (①) гэрэл астал удаан дарна.

→ Өгөгдмөл тохиргоо болох 180°C харагдана.

2 Хүссэн тохиргоогоо сонгохын тулд температурын товчийг эргүүл (④).

→ Индикатор халагч хавчаар ашиглахад бэлэн болох үед анивчихаа болино.







3 Үсээ самнаад, шулуун болгох үсээ 3-5см хооронд байхаар салгана.

Жич: Өтгөн үстэй бол таслах хэсгээ өсгөвөл зүгээр.

4 Халагч хавчаарын хооронд үсээ оруулж (②) бариулыг нь нийлүүлж чанга дарна.

5 Индүүг үсний уртаар нэг хөдөлгөөнөөр алгуурхан гулсуулна (хамгийн ихдээ. 5 секунд) угнаас үзүүр хүртэл, хэт халалтаас урьдчилан сэргийлэхийн тулд зогсоохгүйгээр.

5 Үс буржийлгах








- 1 Үсний үзүүрээс эхлээд 2-3 см хэртээ үсийг салгаж авна. Салгасан үсээ халагч хавчаарын хооронд байрлуулна (②).
- 2 Үсээ гадагш буржийлгах бол шулуун болгогчийг гадагш эргүүлснээр шулуун болгогч үсийг гадагш буржийлгана.
- 3 Шулуун болгогчоор үсний үзүүрийг доош татахдаа үзүүр нь доош чиглэнэ. Бүлээн үзүүрээс барьж тулж болно.
- 4 Үсний үзүүрт хүртлээ шулуун болгогчийг зөөлөн удаан гулсуулна.
- 5 Хуруугаа ашиглан хайчаа сугалж авсны дараа үсээ эргүүлж өгөөрэй.

6 Дотогш харуулж буржийлгах бол шулуун болгогчийг алхам 2-ын дагуу дотогш эргүүлж дээрх алхмуудыг давтаарай.

Зөвлөмж:

- Илүү үр дүнтэй байхын тулд бага зэрэг туг үс ав.
- Эргүүлсний дараа үсний үзүүрийг гараа ашиглан индүүн дээгүүр эргүүлээрэй.
- Индүүний үзүүрийг бариад эргүүлэх, татахад илүү сайн хянана.
- Үсээ татаж байхдаа бариулаа зөөлөн суллана.

6 Хэрэглэсний дараа



- 1 Цахилгаан хэрэгслийг унтраагаад, залгуураас салга.
- 2 Хөрөх хүртэл нь халуунд тэсвэртэй гадаргуу дээр байрлуул.
- 3 Гэр ахуйн хэрэгсэл болох халагч хавчаарыг чийгтэй алчуураар арчиж цэвэрлэнэ үү.
- 4 Аюулгүй, хуурай бөгөөд тоосгүй газарт хадгална уу. Та мөн бариулын гогцоог ашиглан өлгөж болох (⑤) ба дагалдан ирсэн халууны гэрэнд хийгээд хадгалж болно (⑦).

Жич:

- Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг халуунаар нь уутанд хийж болохгүй.
- Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл нь автоматаар унтрах функцээр тоноглогдсон. 30 минутын дараа төхөөрөмж автоматаар унтардаг.

7 Баталгаат хугацаа ба засвар үйлчилгээ

Хэрэв дагалдах хэрэгслүүдийг солих эсвэл танд асуудал гарч мэдээлэл авах хэрэгтэй байгаа бол Philips-ийн www.philips.com/support вэбсайт руу зочлох эсвэл өөрийн улсын Philips Хэрэглэгчийн төвтэй холбоо барина уу (та үүний дугаарыг дэлхийн баталгааны зурагт хуудаснаас олж авч болно). Хэрэв танай улсад Хэрэглэгчийн тусламж үйлчилгээний төв байхгүй бол орон нутгийнхаа Philips-ийн борлуулагчид хандана уу.



Техникийн үзүүлэлтүүд нь урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөнө
© 2021 Koninklijke Philips N.V.
Бүх эрх хамгаалагдсан.

(08/09/2021)

